

Эрүүл мэндийн газрын долоо хоногын мэдээ

Нэг. Зарим статистик үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	20 дахь долоо хоног	Жилийн эхнээс өссөн дүн	Өмнөх онтой харьцуулахад
1	Нийт төрөлт	70	1085	-16
2	Амьд төрөлт	69	1090	-17
3	Амьгүй төрөлт	1	4	-3
4	Дутуу төрөлт	2	59	+6
5	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	27	+4
6	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	4	-2
7	Эхийн ноцтой хүндрэл	0	1	+1
8	Төрөлхийн гажиг	0	6	+3
9	Гэрийн төрөлт	0	3	+1

Хоёр. Томуу томуу төст өвчний мэдээ

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 19 дүгээр долоо хоногт нийт 4661 хүн үйлчлүүлсний 212(4,5%) нь ТТӨ -тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 4.7%-иар буурсан үзүүлэлтэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (159)-ийн дотор буюу 13,2%-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 1,9%-иар нэмэгдсэн үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд үргэн тусламжийн 4 49 дуудлагын 58(12,9%)-ийг ТГ -ий шалтгаантай дуудлага эзэлж байсан өмнөх долоо хоногтой харьцуулахад 9,9 %-иар буурсан үзүүлэлтэй байна.

Гурав. Нийгмийн эрүүл мэнд

1. Дэлхий дахинд улаанбурхан өвчний дэгдэлт гарч байгаа улс орны тоо нэмэгдэж, өвчлөл өмнөх оноос 4 дахин ихэссэн байдалтай байна. Манай улсад Энэтхэг улсаас өвөрлөгдөн орж ирсэн тохиолдол бүртгэгдэж, зарим насны хүн амд улаанбурхан өвчний эсрэг дархлааны түвшин хангалтгүй байгаа зэрэг тархвар судлалын өжцөл байдалтай уялдуулан улаан бурханы эсрэг нэмэлт

дархлаажуулалтыг улсын хэмжээнд 2019 оны 05 дугаар сарын 15-аас 25-ны өдөр “УЛААНБУРХАН ӨВЧИНД ЦЭГ ТАВЬЯ” уриан дор зохион байгуулж байна.

Нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах, дархлаажуулалтын бичил өлөвлөгөө боловсруулах зэрэг бэлтгэл ажлын үрээнд 05 дугаар сарын 13 -ны өдөр сум дундын эмнэлэг, сум өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга, эрхлэгч нар болон вакцина тооуудад сургалт зохион байгуулж, холбогдох мэдээллийгч, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.

Дархлаажуулалтын 10 хоногийн нээлтийн үйл ажиллагаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн газрын санхүүжилтээр 05 дугаар сарын 16-ны өдөр Спорт цогцолборт зохион байгуулагдсан.

Дархлаажуулалтын 10 хоногоор 5-18 насны 29000 гүүхүүдийг дархлаажуулахаар төлөвлөсөн байгаа ба ХӨСҮТ-өөс 32700 хүн тун Улаанбурхан, улаануудын эсрэг вакцин, 31200ш 0,5мл өөрөө эвдэрдэг тариур, 3300ш 5 мл -ийн өөрөө эвдэрдэг тариур, 265 ш аюуий хайрцаг болон сургалт сурталчилгааны материалуудыг хүлээн авч, нэгжүүдэд хуваарилж, түгээсэн.

2019 оны 05 дугаар сарын 15-ны өдөр 16 нэгжээс нэмэлт дархлаажуулалтын хамралтын мэдээг авахад, 3857 хүүхдийг вакцинд хамруулсан байна.

2. Сум тосгоны ЭМТөв, сум дундын эмнэлгүүд ийн эрхлэгч, дарга нарт цахим хурал хийж цаг үеийн асуудлаар ЭМГазрын зарим мэргэжилтнүүд мэдээлэл хийлээ.
3. Эрүүл хүнс сарын аяны хүрээнд Өлгий сумын 1, 2, 12 дугаар багуудын хүнсний дэлгүүрүүд болон хүүхдийн 4, 7, 8, 17 дугаар цэцэрлэгүүд, 1 дүгээр бага сургуулиар орж хүнсний бүтээгдэхүүний хугацаа, хадаглалт, хаяг шошиго, ариун цэврийн байдалд хяналт шалгалт хийж худалдагч нарт эрүүл ахуйн заварчил гаа өгсөн.
4. Сүрьеэгийн тасагт эрчимт эмчилгээний хугацаа дууссан 5 өвчтөнийг Толбо, Дэлүүн, Улаанхус сумын эрүүл мэндийн төвүүд, Мейрим, Раушан ӨЭМТ -үүдэд үргэлжлэх шаштны эмчилгээ хийлгэхээр гурвалсан гэрээгээр шилжүүлээ.